



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 604

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2019 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 213.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг” улсын төсөвт үйлдвэрийн газарт хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Х.Бат-Ирээдүйд дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Урсгал төсөв, давсан орлогоос бэлтгэх хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хуулиар тогтоосон журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан авч, зөрчлийг таслан зогсоох;

2.2. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх тохиолдолд Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх тухай 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг баримтлан ажиллах;

2.3. “МИТПС” ХХК, “Очир принтинг” ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээг цуцалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн байгуулах;

2.4. “МИТПС” ХХК-иар гүйцэтгүүлсэн программ хангамж боловсруулах ажлын гэрээг дүгнэх, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох;

2.5. “И Эм Си Эйч Инженеринг” ХХК, “Хосхан” ХХК-д түрээслүүлж буй байр талбайн хэмжээг шинэчлэн тогтоох, 2 талын баталгаажуулснаар гэрээнд өөрчлөлт оруулах, гэрээг шинэчлэн байгуулах арга хэмжээ авах;

2.6. Нийслэлийн Хан-Уул дүүрэгт байрлалтай, саам сувиллын барилгын газар, Төв аймгийн Аргалант сум, Хөшөөт баг, Молцог элсэн дэх 2 га газартай холбоотой газрын зөрчлийг арилгах;


2.7. Ашиглалтгүй байгаа MRI аппаратад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, цаашид гарах засвар үйлчилгээний болон бусад урсгал зардал, хөрөнгийн нөхөн хангалт, эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

2.8. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн
604 дугаар тогтоолын хавсралт



Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт хийсэн хяналт шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөг/, Газрын хэмжээ /м.кв/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Давсан орлогоос эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, нөхөн шийдвэр гаргуулсан	Эмнэлгийн удирдлага, захиргаа Санхүү, хангамжийн алба	213.5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
Дүн:			213.5		
2	Үл хөдлөх хөрөнгө (Саам сувиллын барилга) нь бусдын эзэмшил газарт байршсан	Эмнэлгийн удирдлага, захиргаа Санхүү, хангамжийн алба	-	-	Үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
3	Газрын эзэмших эрх кадастрын зураглалгүй	Эмнэлгийн удирдлага, захиргаа Санхүү, хангамжийн алба	20,000.0	-	Газрын эзэмших эрхэд кадастрын зураглал хийлгүүлэн, баталгаажуулах арга хэмжээ авах.
Дүн:			20,000.0		